



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ

**МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141
Утас: 26 42 16, Факс: (976-51) 26 44 60,
Цахим шуудан: info@csc.gov.mn,
Цахим хуудас: www.csc.gov.mn

2024.12.02 № 03/2533
танай _____-ны № _____-Т


Тайлан хүргүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 136 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдвээр яам, агентлаг, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хүний нөөцийн аудитын тайланг хүргүүлж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 80 дугаар тогтоолоор баталсан “төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх журам”-ын 14.4-д заасны дагуу аудитын тайланг холбогдох байгууллагуудад танилцуулж, тайлбар, саналыг авч нэгтгэн 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлэхийг хүсье.

Хавсралт ³⁵ хуудастай

ГИШҮҮН  Б.ПҮРЭВДАГВА



24008371

Төрийн албаны зөвлөлийн
2024 оны ... сарын ... ны
өдрийн ... тогтоолын хавсралт



**МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

**ЯАМ, АГЕНТЛАГ, НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГАД ХИЙСЭН ХҮНИЙ НӨӨЦИЙН
АУДИТЫН НЭГДСЭН ТАЙЛАН (2024)**

Хүний нөөцийн аудитын сэдэв:

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ЧИГ ҮҮРЭГ ХЭРЭГЖҮҮЛДЭГ ХҮНИЙ
НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, СУРГАЛТ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

Аудитын код:
ТАЗ-ХНУАГ-202401

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	3
АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	3
АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ.....	4
АУДИТЫН МЭДЭГДЭЛ.....	5
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
БҮЛЭГ 1.ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН “ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЯЛДУУЛСАН, ХӨТӨЛБӨРТ СУУРИЛСАН БАЙДЛААР ТӨЛӨВЛӨХ” ГЭСЭН ЗАРЧИМТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.....	8
1.1. Монгол улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын “Цахим Монгол” зорилтыг хэрэгжүүлэх 86 зорилт арга хэмжээнд мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, үйл ажиллагаа тусаагүй байна.....	8
1.2.Хөгжлийн урт хугацааны баримт бичигт туссан мэдээллийн технологийн чиглэлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх салбарын хүний нөөцийн ажиллах нөхцөлийг дэмжсэн урт хугацааны, цогц бодлогыг хэрэгжүүлээгүй байна.....	11
Дүгнэлт	12
БҮЛЭГ 2. ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫГ НЭГДСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРТ СУУРИЛСАН БАЙДЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙГАА НЬ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙД НИЙЦСЭН, САНХҮҮЖИЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОДОРХОЙ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЯЛДСАН, ХЭРЭГЖИХҮЙЦ БАЙДЛААР ТӨЛӨВЛӨХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХГҮЙ БАЙНА.	14
2.1. Аймаг, нийслэл, төрийн захиргааны төв байгууллагуудын хүний нөөцийн бодлого, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний санхүүжилт, үнэлгээний шалгуур тодорхой бус байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай нийцэхгүй байна.....	14
2.2. Төрийн байгууллагуудын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрт мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжсэн арга хэмжээ тусаагүй байна.....	16
Дүгнэлт	20
БҮЛЭГ ГУРАВ. ТӨРИЙН АЛБАНЫ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ АЖИЛЛАХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ДУТАГДАЛ ИХ БАЙГАА НЬ МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТ ХЭРЭГЖИХЭД ЭРСДЭЛ ҮҮСГЭХ НӨХЦӨЛ БҮРДЭХЭЭР БАЙНА.....	21
3.1.Төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр батлагдсан 728 орон тооны 150 орон тоо сул, эзэнгүй, 142 орон тоонд мэргэжлийн бус албан хаагчид ажиллаж байгаа нь нийт орон тооны 40.1%-ийг эзэлж байна.	21
3.2. Зарим яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн технологийн хүний нөөцийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэхгүй байна.	24
Дүгнэлт	26

БҮЛЭГ ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАНЫ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ ОЛОН УЛСЫН ДУНДЖААС 25.8%-ИАР, УЛСЫН ДУНДЖААС 21.1%-ИАР ДООГУУР БАЙНА.....	28
4.1.Төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг 37.8 хувьтай байна.....	28
4.2.Төрийн өгөгдлийн сангууд, түүний бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангах, улмаар төрийн байгууллагуудад мэдээллийн шинэ технологийн (их өгөгдлийн технологи, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжлэх ухаан г.м) мэдлэг, ур чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх сорилт тулгарч байна.....	31
Дүгнэлт	33

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

1	АЕГ	Архивын ерөнхий газар
2	АИТХТ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгч
3	БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
4	БЯ	Боловсролын яам
5	ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
6	ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
7	ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
8	ЖДҮГ	Жижиг дунд үйлдвэрийн газар
9	МТ	Мэдээллийн технологи
10	МТТ	Мэдээллийн технологийн төв
11	МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
12	НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
13	ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
14	СХЗГ	Стандарт хэмжил зүйн газар
15	СЯ	Сангийн яам
16	УОНТ	Улс орон нутгийн төсөв
17	ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
18	ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
19	ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. МТ-ийн өндөр ур чадвартай төрийн албан хаагчдын орон тооны мэдээлэл
Хүснэгт 2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн мэдээлэл /байгууллагаар/
Хүснэгт 3. МТ-ийн албан хаагчдын мэдээлэл, ажилласан жилээр
Хүснэгт 4. МТ-ийн албан хаагчдын орон тооны мэдээлэл, албан тушаалын ангиллаар
Хүснэгт 5. МТ-ны албан хаагчдын орон тооны мэдээлэл, албан тушаалын төрлөөр
Хүснэгт 6. МТ-ны албан хаагчдын мэдээлэл, мэргэжлээр
Хүснэгт 7. МТ-ны албан хаагчдын мэдээлэл, боловсролын зэргээр
Хүснэгт 8. ТЗ-ны албан хаагчдын мэдээлэл, түшмэлийн ангиллаар
Хүснэгт 9. ТҮ-ны албан хаагчдын мэдээлэл, албан тушаалын зэрэглэлээр
Хүснэгт 10. МТ-ийн албан хаагчдын цалин хөлсний мэдээлэл
Хүснэгт 11 . МТ-ийн албан хаагчдын мэдлэгийн түвшин, ОУ-ын болон Монгол Улсын дундажтай харьцуулснаар
Хүснэгт 12. МТ-ийн албан хаагчдын мэдлэгийн түвшин, шалгалтын агуулгаар
Хүснэгт 13. МТ-ийн эрэлт өсөж байгаа мэргэжлийн чиглэл, улсаар
Хүснэгт 14 . МТ-ийн чиглэлийн ажилтны өсөлтийн таамаглал

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1. МУ-ын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилт, арга хэмжээ
Дүрслэл 2. МТ-ийн албан хаагчдыг богино болон зорилтот сургалтад хамруулсан байдал
Дүрслэл 3. МТ-ын албан хаагчдын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байдал
Дүрслэл 4. МТ-ийн албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардал /2019-2024 он, төгрөгөөр/
Дүрслэл 5. МТ-ийн албан хаагчдын шагналын мэдээлэл

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Хавсралт 1. Яам, агентлагийн хүний нөөцийн бодлого, сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн мэдээлэл

Хавсралт 2. Аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн бодлого, сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн мэдээлэл

Хавсралт 3. Хуульд заасан нийгмийн баталгааны чиглэл, түүний хэрэгжилт

АУДИТЫН МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл

Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.1.2.6, 6.1.1, 6.1.5, 6.1.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх журам”-ын 5.4.3, 5.5, 8.1.8 дахь заалт, 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Хүний нөөцийн аудитын сэдэв, төлөвлөгөө батлах тухай” 156 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны “Хүний нөөцийн аудитын бүрэлдэхүүн удирдамжийг батлах тухай” 136 дугаар тушаалыг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын сэдэв:

“Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн”

Аудитын зорилго, зорилт:

Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлого, арга хэмжээний явц, үр дүнг тооцож, дүгнэлт өгөх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, шийдвэр гаргуулахад хүний нөөцийн аудитын зорилго оршино.

Аудитын дэд зорилт:

1.Төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх урт, дунд хугацааны бодлого, арга хэмжээний уялдаа холбоо оновчтой эсэхийг тодорхойлж, явц, үр дүнг үнэлнэ.

2.Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын төлөв байдлыг үнэлнэ.

3.Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлт, нийгмийн баталгааг үнэлнэ.

4.Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварын түвшинг тодорхойлно.

Аудитын хамрах хүрээ, хугацаа:

Хүний нөөцийн аудитад яам, агентлаг, орон нутгийн захиргааны 584 байгууллага, 840 албан хаагчийг хамруулахаас 16 яам, аймаг нийслэлийн 161 байгууллагын 432 албан хаагчийг хамруулан ажиллаж байна.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 3000, Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх журам, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 5 дугаар хуралдаанаас зөвшөөрсөн “Хүний нөөцийн аудит хийх гарын авлага”-д дурдсан арга зүйн дагуу аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултуудад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг нягтлан шалгах, баримт бичгийн шинжилгээ, харьцуулалт, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, түүвэрлэн шалгах, шалгуур үзүүлэлттэй харьцуулах, үр дүнг тооцох, түүвэр судалгаа, асуулга авч үр дүнг нэгтгэх зэрэг аудитын арга зүйг ашиглаж байна.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн акт, бодлогын баримт бичгийг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглаж байна.

Бодлогын баримт бичиг:

- Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого
- Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”
- Улсын Их Хурлын 2020 оны 23-р тогтоолоор баталсан “ Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
- Улсын Их Хурлын 2020 оны 23-р тогтоолоор баталсан “Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
- Монгол Улсын хөгжлийн 2022, 2023 оны төлөвлөгөө.

Хууль тогтоомж:

- Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Архивын тухай хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
- Холбогдох бусад хууль

Тогтоол, дүрэм, журам

- Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, холбогдох бусад байгууллагаас батлан хэрэгжүүлж буй тогтоол, шийдвэр, эрх зүйн актууд.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитын багийг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Пүрэвдагва ахалж, гишүүдэд Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах, Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын Мэдээллийн технологийн хэлтсийн референт С.Батнасан, Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын референт Д.Даваасамбуу, Г.Галбаяр, ахлах шинжээч П.Оюунчимэг, Г.Нансалмаа, шинжээч Д.Энхтулга, С.Энхжин, Н.Энхтуяа, Б.Чойжилсүрэн, ахлах зохион байгуулагч О.Дашдондог нар ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар батлагдсан аудитын баг 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд тогтоосон чиглэлээр аудит хийж, аудитын үр дүнг нэгтгэн аудитын нэгдсэн тайланг боловсруулав.

Аудитын хязгаарлалт

Төрийн албаны зөвлөлөөс 2019-2024 онд хийсэн хяналт шалгалт, төрийн жинхэнэ албан хаагчдыг сонгон шалгаруулж, томилсон, чөлөөлсөн, бусад маргаантай асуудлаар Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлд гаргасан өргөдөл, мэдээлэлтэй холбогдуулан хяналт шалгалт хийсэн болон хийгдэж буй асуудлыг аудитад хамруулаагүй болно.

Аудитад Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар гэсэн бүтэц, орон тоо, чиг үүрэг нь төрийн болон албаны нууцад хамаарах төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудыг хамруулаагүй болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн байгууллагын үйл ажиллагааны шинэчлэлийн нэг хэлбэр нь мэдээллийн технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, цахим засаг, цахим засаглал буюу ухаалаг засаглалын тогтолцоог бүрдүүлэн, хөгжүүлэх явдал юм.

“Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийгэм, эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн инновац, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан ашиглах боломжийг нээх, төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд дахин инженерчлэл хийж, оновчтой, үр ашигтай засаглалыг бэхжүүлэх, төрийн их өгөгдлийн мэдээллийн санг бүрдүүлэн түүнийг бодлого боловсруулах, шийдвэр гаргах, тоон эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд ашиглаж, үндэсний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилтыг тавин, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахад төрийн байгууллагад ажилладаг мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжил, нийгмийн баталгааг хангах зэрэг хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа, түүний үр дүн чухал ач холбогдолтой юм.

Иймд ТАЗ-өөс Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн энэхүү аудит нь төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хүний нөөцийн бүрдүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, мэдлэг, ур чадварын түвшинг тогтоох, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, гүйцэтгэлийн явцад оршиж байгаа ололт болон сул байдлыг чухалчлан тэмдэглэж үр дүнгийн байдлыг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх сургалт хөгжлийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, илэрсэн сөрөг үр дагаврыг арилгаж, эрсдэлийг бууруулах, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулахад чиглэв.

БҮЛЭГ 1.ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН “ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЯЛДУУЛСАН, ХӨТӨЛБӨРТ СУУРИЛСАН БАЙДЛААР ТӨЛӨВЛӨХ” ГЭСЭН ЗАРЧИМТАЙ НИЙЦЭХГҮЙ БАЙНА.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйл “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн төрөл”-ийн 6.5.1 дэх заалтад “**хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр**”, Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... Хөгжлийн зорилтот хөтөлбөр, ... -ийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн албаны ажилтан **бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах** арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.”, Төрийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Засгийн газар ... хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн **төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.**” гэж тус тус заасан. Дээрх хууль эрх зүйн хүрээнд Засгийн газраас хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр болон төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийг нэгдсэн байдлаар боловсруулж, хэрэгжүүлээгүй байна.

Төрийн албаны хүний нөөцийн бодлого үйл ажиллагаа нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг түүнтэй уялдан гарсан дунд, богино хугацааны бодлого баримт бичиг болох Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол Улсын хөгжлийн тухайн жилийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдэд төрийн албаны хүний нөөцийн болон мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн талаар туссан зорилт, арга хэмжээ, үйл ажиллагаа түүний хэрэгжилтийн байдалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

1.1. Монгол улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын “Цахим Монгол” зорилтыг хэрэгжүүлэх 86 зорилт арга хэмжээнд мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, үйл ажиллагаа тусаагүй байна.

“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Цахим Монгол” зорилтыг дэвшүүлж, үүнтэй уялдуулан дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт цахим шилжилтийн үеийн 86 зорилт, арга хэмжээ тусгагдсан байна.

Эдгээр зорилт арга хэмжээний 89.6% нь мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох, техник технологийг хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бий болгох, орон зайн болон газар зүйн мэдээллийн системийг шийдвэр гаргалтад ашиглах, төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үйл ажиллагааг дэмжих, төрийн үйлчилгээг хялбаршуулах, цахимжуулахад чиглэсэн **мэдээллийн технологийн техник хангамж болон программ хангамжийг хөгжүүлэх** талын үйл ажиллагааг төлөвлөсөн бол 10.4% нь төрийн албан хаагчдыг сургах, мэдээлэл технологийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа байна.

Төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэхэд гол тулгуур нөөц болох төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг ур, чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, сургалт хөгжлийн орчин нөхцөлийг сайжруулах, алсын зайнаас суралцах боломжийг бүрдүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой дээрх 10.4 хувь буюу 3 зорилт, 6 арга хэмжээг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт дараах байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх 2021-2030 оны үйл ажиллаганы төлөвлөгөөний “5.3.18.Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлнэ” гэж, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн “Зорилт 5.4.4.Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлнэ” гэж, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “4.2.6.Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно” гэж тус тус заажээ.

Дүрслэл 1. МУ-ын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилт, арга хэмжээ

<p>“Алсын хараа-2050”</p> <p>Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба Зорилт 5.4.Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.</p> <p>Зорилт 5.3.Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.</p>	<p>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</p> <p>5.3.18.Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлнэ.</p>	<p>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл</p> <p>Зорилт 5.4.Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ:</p> <p>5.4.4.Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.</p>	<p>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр</p> <p>4.2.6.Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.</p> <p>Арга хэмжээ:</p> <p>-Сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчилж, онлайн хэлбэрт шилжүүлнэ. /33.612 сая/ -Сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулах /4,000.0 сая/ -Сонсогчийн байр-/37,656 сая/</p>
---	--	---	--

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө” 4.2.2.Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим сургалтыг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологийн төвийг байгуулах

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө” 3.1.2.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн албан хаагчдын цалин хөлсний системийг бүтээмж, ажлын үр дүнтэй уялдуулан шинэчилж, цалин хөлсийг нэмэгдүүлэх

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө” 3.2.3.Төрийн албаны хүний нөөцийн тогтвортой

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТЭЭС

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа, төсөв	Биелэлт
<p>4.2.6.1.Төрийн албан хаагчдад зориулсан сургалт судалгаа, зөвлөх үйлчилгээ үзүүлж, сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчилж, онлайн хэлбэрт шилжүүлнэ.</p>	<p>2020-2024 он</p> <p>/33.612 сая/</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 312 дугаар тогтоолоор Удирдлагын академийн богино, дунд хугацааны сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчилсэн. Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу сургасан албан хаагчдын тоо 90,119 /үүнээс танхимаар 13,537, цахимаар 76,582/, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу сургасан албан хаагчдын тоо 6,257, нийтдээ Удирдлагын академи 96,376 төрийн албан хаагчдыг сургасан. Удирдлагын академийн нийт 6 судалгаа хийж, 2 зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, төрийн байгууллагууд</p>

		болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн нийтдээ 36 судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулсан. Сургалтын хөтөлбөрийн агуулгын шинэчлэл 85 хувьтай байна.
4.2.6.2. Орчин үеийн шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулж, цахим-сургалтыг нэвтрүүлэх	/4.000.0 сая/	“Төрийн албаны онлайн сургалтын платформ”-ыг хийж, 6 онлайн хичээл, 3 live хичээл бэлтгэн байршуулсан. “Алсын Хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 42 богино хугацааны видео хичээл, 8 сургалтын контент бэлтгэж, цахим сургалтад 5000 албан хаагч хамрагдсан. Анги танхимыг иж бүрэн тохижуулж олон улсын хурал, семинар зохион байгуулах боломж бүхий орчин үеийн сургалт, хурлын тоног төхөөрөмж суурилуулсан. Сүлжээ сервер, хамгаалалтын тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, утасгүй интернэтийн сүлжээнд хичээлийн анги, танхим бүрийг холбосон.Харилцаа холбооны бүрэн шинэчлэл хийж IP технологид суурилсан холбоо системийг 2022 оны 02 дугаар сараас ашиглаж эхэлсэн. Нийт багш, ажилтнуудын компьютер тоног төхөөрөмжийн шинэчлэлийг 100 хувь хийсэн. Техникийн хүчин чадлын дундаж үзүүлэлт i7 доошгүй CPU, лицензтэй Windows үйлдлийн систем бүхий зөөврийн компьютероор багш нар 100 хувь, суурин компьютероор ажилтнууд 100 хувь хангагдсан.
4.2.6.3. Олон улсын стандартын шаардлагад нийцсэн төрийн албан хаагчдын сурах бололцоог хангасан мэдээллийн технологийн төв, сонсогчийн байр барина.	/37.656 сая/	Олон улсын стандартын шаардлагад нийцсэн албан хаагчдын сурах бололцоог хангасан Сонсогчийн байр нь сургалт, мэдээллийн төвийн байр, сонсогчийн дотуур байр, спорт заал бүхий 3 корпустай байхаар зураг, төсөв хийлгэсэн. Нийт талбайн хэмжээ 11,621.1 м.кв, төсөвт өртөг нь 18,827.2 сая төгрөг. “Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай” хуульд “V.1.1.22 Удирдлагын академи кампус, өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/” нэртэйгээр 500.0 сая төгрөг, 2022 оны Төсвийн тухай хуульд 2,498.2 сая төгрөг санхүүжүүлэхээр тусгагдсан ба уг санхүүжилтээр хуучин барилгыг буулгах, цахилгааны дэд өртөөний барилгын ажил хийгдэж дууссан. Сонсогчийн байр барихад улсын төсөвт нийт 5.7 тэрбум төсөвлөснөөс 5.6 тэрбум шилжигдэж зарцуулагдсан. Ус, дулаан дамжуулах төв бүрэн ашиглалтад орсон, А блокийн суурь цутгагдсан, Б блокийн гүйцэтгэл 70 хувьтай байна.

(Эх сурвалж Засгийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан)

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан дээрх зорилт нь аймаг, нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, төрийн байгууллагуудын стратеги төлөвлөгөөнд төрийн албан хаагчийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, сургалт, нийгмийн баталгааг дэмжиж ажиллах зэрэг ерөнхий байдлаар тусгагдсан байна.

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ нь хоорондоо уялдсан, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгалаа олсон хэдий ч төрийн албаны мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх, сургах хөгжүүлэх, тогтвортой ажил эрхлэлтийг дэмжсэн бодлогын зорилт арга хэмжээ тусгагдаагүй байна.

1.2.Хөгжлийн урт хугацааны баримт бичигт туссан мэдээллийн технологийн чиглэлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх салбарын хүний нөөцийн ажиллах нөхцөлийг дэмжсэн урт хугацааны, цогц бодлогыг хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт төрийн албаны мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх, сургах хөгжүүлэх, тогтвортой ажил эрхлэлтийг дэмжсэн урт хугацааны, нэгдсэн бодлого зорилт арга хэмжээг тусгаагүй боловч төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын ажиллах, нөхцөл нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор МУЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 213 дугаар тогтоолыг баталсан байна.

Уг тогтоолоор “Төрийн албанд ажиллах мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтны албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр”, “Мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтан ажиллуулах төрийн байгууллагын жагсаалт, мэдээллийн технологийн чиглэлээр ажиллах ажилтны орон тооны дээд хязгаар”-ыг тус тус баталжээ.

Тогтоолд 75 байгууллагын нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар шаардах 181 албан тушаалын жагсаалтыг баталсан. Энэ жагсаалтад дурдсанаар аудитад хамрагдсан нийт байгууллагын 73 байгууллага нь 62 албан тушаалд нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай албан хаагчийг ажиллуулах боломжтой 2024 оны 09 дүгээр сарын 26-ны байдлаар аудитад хамрагдсан 8 яам, 13 агентлаг, Дундговь аймгийн ЗДТГ зэрэг нийт 22 байгууллага 33 албан тушаалд нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай албан хаагчийг ажиллуулж байна. Эдгээр 33 ажилтны 25 нь гүйцэтгэх албан тушаалд 4.803.200 төгрөгийн, 8 нь туслах албан тушаалд 3.539.200 төгрөгийн цалинтай ажиллаж байна.

Эдгээрээс 11 нь “Программ хангамж”, 3 нь “Мэдээллийн технологи”, 1 нь “Мэдээллийн сүлжээ”, 4 нь “Мэдээллийн систем”, 1 нь “Мэдээллийн аюулгүй байдал”, 1 нь Компьютерын график дизайн, 2 нь “электроник, электрон системийн инженер”, 2 нь “Холбооны инженер”, 1 нь Мультимедиа технологи, 1 нь Санхүүгийн технологийн бакалаврын зэрэг эзэмшсэн, харин бусад 6 буюу ГЗБГЗЗЕГ-ын 1 ажилтан нь “Газрын инженер”, “Байгалийн аялал жуулчлалын менежер”, ГИХГ -ын 1 ажилтан Инженерийн математик загварчлал, ЗТХЯ-ны 1 ажилтан “Бизнэсийн удирдлага”, ХББОСЯ-ны 1 ажилтан “Геофизикийн инженер”, БОУАӨЯ-ны 1 ажилтан, СХЗГ-ын 1 ажилтан “Менежмент маркетинг”-ийн мэргэжилтэй байна.

ГЗБГЗЗЕГ, ХББОСЯ, ГИХГ, СХЗГ-ын ажилтнууд нь мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн сүлжээгээр мэргэшсэн ОУ-ын стандартын байгууллагын сургалтаар олгогдсон сертификаттай. БОУАӨЯ, СХЗГ-ын ажилтнууд нь одоо мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж байна.

Магистрын боловсролын зэрэгтэй 6 ажилтан байна. Дээрх албан хаагчдын Хөдөлмөр эрхлэлтийн түүхийг харвал 10 нь одоогийн байгууллагадаа ажиллаж байсан, 23 нь дээрх тогтоолын дагуу төрийн албанд шинээр томилогдсон ажилтан байна.

Хүснэгт 1. МТ-ийн өндөр ур чадвартай төрийн албан хаагчдын орон тооны мэдээлэл

Д/д	Байгууллагын нэр, албан тушаал	Батлагдсан Орон тоо			Одоо ажиллаж байгаа			Бүтэцдээ оруулж баталсан орон тоо	Үлдсэн орон тоо /батлагдсан орон тоонд эзлэх хувь/
		Нийт	ТҮМТ-1-1	ТҮМТ-2-1	Нийт	ТҮМТ-1-1	ТҮМТ-2-1		
1	Яам	40	19	21	10	7	3	10	30 (75%)

2	Агентлаг	58	38	20	22	17	5	22	36 (62%)
3	Нутгийн захиргааны байгууллага	64	32	32	1	1		1	63 (98.4%)
	Нийт	162	89	73	33	25	8	33	129 (79.6%)

Мэдээллийн технологийн өндөр ур чадвартай ажилтан ажиллуулж байгаа 8 яам, 13 агентлагийн зарим яам, агентлагийн мэдээллийн технологийн албан хаагчид байгууллагын мэдээллийн систем, сүлжээ, сервер, техник тоног төхөөрөмжид мониторинг хийж, тасралтгүй, хэвийн найдвартай үйл ажиллагаа, нууцлалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахаас гадна, тогтмол шинэчилж, сайжруулах, үр ашигтай шинэ техник технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, системүүдийн хооронд уялдаа холбоо үүсгэн, сайжруулалтыг хийх, мэдээллийн их өгөгдлийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, шинэ инновацыг нэвтрүүлэх дэд бүтцийг бий болгох, салбарын байгууллагууд үйл ажиллагааг автоматжуулж цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор 300 сумдыг шилэн кабелиар өндөр хурдны VPN сүлжээнд холбон бодит цагийн горимд холбогдон ажиллах боломжийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, нууцлалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох дүрэм, журам, боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангуулах зэрэг нарийн мэдлэг, ур чадвар шаардсан чиг үүргүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал: Сангийн яам 18 систем, дата төв, Татварын ерөнхий газар 5 систем, мэдээллийн технологийн төвийн тоног төхөөрөмжийг хариуцан ажилладаг бол Монополын эсрэг газрын албан хаагч байгууллагын компьютер, принтер, дотоод сүлжээний бэлэн байдал, албан бичиг хэрэг солилцооны системийг хариуцан ажиллаж байна.

Төрийн албанд ажиллах мэдээллийн технологийн хүний нөөцийн ажиллах нөхцөлийг дэмжсэн бодлого (Засгийн газрын 2023 оны 213 дугар тогтоол)-д мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий ажилтны эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, нөхцөл, шалгуур, төрийн байгууллагуудын тухайн үеийн орон тооны хүрээнд зохицуулалт хийх эсэхийг тодорхой заагаагүй, “мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвар”-тай хүнийг сонгон шалгаруулах үйл явц, шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг арга замыг тодорхой тусгаагүйгээс төрийн албанд ажиллах мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийг оновчтой бүрдүүлэх, тогтоон барих, тогтвор суурьшилтай ажиллуулахад тодорхой ахиц гарахгүй байна.

Дүгнэлт

1.Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт мэдээллийн технологийг хөгжүүлэх чиглэлээр томоохон зорилт, арга хэмжээнүүдийг тусгасан, тэдгээр нь хоорондоо уялдсан, санхүүгийн эх үүсвэрийг тодорхой заасан байна.

2.Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээг тодорхой хэмжээнд тусгаж, энэ нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгалаа олсон хэдий ч Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан хөтөлбөрт суурилсан байдлаар төлөвлөгдөөгүй байна.

3.Бодлогын баримт бичигт туссан төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээнд төрийн албаны мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх, сургах хөгжүүлэх, тогтвортой ажил эрхлэлтийг дэмжсэн бодлогын зорилт арга хэмжээ тусаагүй байна.

4.МУЗГ-аас гаргасан шийдвэр төрийн албаны мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх, сургах хөгжүүлэх, тогтвортой ажил эрхлэлтийн асуудлыг нэгдсэн, цогц байдлаар шийдээгүйгээс энэ салбарын хүний нөөцийг оновчтой бүрдүүлэх, тогтоон барих, тогтвор суурьшилтай ажиллуулахад тодорхой үр дүн үзүүлэхгүй байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫГ НЭГДСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРТ СУУРИЛСАН БАЙДЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙГАА НЬ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙД НИЙЦСЭН, САНХҮҮЖИЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОДОРХОЙ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЯЛДСАН, ХЭРЭГЖИХҮЙЦ БАЙДЛААР ТӨЛӨВЛӨХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХГҮЙ БАЙНА.

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэгт “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.” 66 дугаар зүйл “Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрх”-ийн 66.1.2 дахь заалтад “төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэшил, арга зүйн туслалцаа үзүүлэх, ...”, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.10 дахь заалтад “Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн үнэлгээг ... гаргаж, ... Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.”, 9.12 дахь заалтад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар шаардлагатай ... яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын жилийн үйл ажиллагааны нэгдсэн үнэлгээг гаргана.” гэж тус тус заасны дагуу төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн байгууллага үнэлж ЗГХЭГ-г хүргүүлэхээр, яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын хөтөлбөрийн жилийн нэгдсэн үнэлгээг ЗГХЭГ хийж, Төрийн албаны зөвлөл хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөөр байна.

Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 26 чиглэлийг агуулсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн байдаг.

Аудитад хамрагдсан төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн зорилгыг мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, орчин үеийн төрийн албан хаагчийн онцлогийг тусгасан ур чадвар хөгжүүлэх, дадлагажуулах, мэргэшүүлэх үр нөлөө бүхий сургалтыг зохион байгуулах, алсын зайнаас суралцах орчин нөхцөл бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглүүлэн ерөнхий байдлаар боловсруулсан байна.

Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлж байгаа нийт 578 албан хаагчийн сургалт, хөгжлийг 2019-2024 оноор аудитын хүрээг тогтоон авч үзлээ.

2.1. Аймаг, нийслэл, төрийн захиргааны төв байгууллагуудын хүний нөөцийн бодлого, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний санхүүжилт, үнэлгээний шалгуур тодорхой бус байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай¹ нийцэхгүй байна.

Аудитад хамрагдсан 14 яам, 32 агентлагийн 7 (БЯ, ГБХНХЯ, СЯ, ЭХЯ, ГИХГ, ОӨГ, АЕГ) нь “Хүний нөөцийн хөгжлийн стратеги”-ийн баримт бичигтэй, 28 нь төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөртэй, 38 нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн

¹ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5. “Хөгжлийн зорилтот хөтөлбөр” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичгийг;

баталгааг хангах хөтөлбөртэй байна. Дээрх байгууллагууд нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээрээс 13 яам, 32 агентлагийн хөтөлбөр, төлөвлөгөө нь шинэчлэн найруулсан ТАТХ хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс буюу 2019 оноос хойш, 1 (Сангийн яам) нь 2019 оноос өмнө батлагдсан байна. /Хавсралт 1-ыг үзнэ үү/

Хүний нөөцийн хөгжлийн стратегитай 4 яам, 3 агентлагийн 3 нь бодлогын баримт бичгээ 3-4 жилд, 1 нь 6 жилд, 2 нь 10 жилд хэрэгжүүлэхээр баталсан бол үлдсэн 1 (ГБХНХЯ) нь хэрэгжүүлэх хугацаагаа тодорхойлоогүй байгаа нь гүйцэтгэл хангагдахгүй, үнэлж дүгнэх боломжгүйд хүргэхээр байна.

Харин 22 аймаг, нийслэлийн 14 аймаг нь аймгийн төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах бодлогын баримт бичгийг нэгдсэн байдлаар боловсруулж 11 нь АИТХТ-ийн тогтоолоор, 3 (Орхон, Төв, Хөвсгөл) нь аймгийн Засаг даргын захирамжаар баталсан байдаг бол 7 (Архангай, Баянхонгор, Говьсүмбэр, Завхан, Увс, Ховд, Нийслэл) нь төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг байгууллага тус бүр байгууллагын даргаар батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өмнөговь аймаг аймгийн төрийн албаны хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах бодлогын баримт бичгийг журамлаж, журмыг үе шаттай хэрэгжүүлэх (тус журмын 5.1-д “Журмыг 1 үе шаттай хэрэгжүүлнэ.”)-ээр заасан нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга **давтагдах шинжтэй** шийдвэрийг ойлгоно.” гэж заасантай нийцэхгүй байна.

Дархан-Уул аймгийн төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг баталж, мөрддөггүй, харин энэ талаар жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн, төлөвлөгөө баталж, хэрэгжүүлдэг байна.

Нэгдсэн хөтөлбөртэй 10 аймгийн хөтөлбөр, төлөвлөгөө нь шинэчлэн найруулсан ТАТХ хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс буюу 2019 оноос хойш, 4 нь 2019 оноос өмнө батлагдсан байна. /Хавсралт 2-ыг үзнэ үү/

Хүний нөөцийн хөгжлийн стратегитай 4 яам 3 агентлагийн 1 нь хүний нөөцийн хөгжлийн баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй, 2 нь үнэлэх шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, бодлогын баримт бичгийг үнэлэх журамтай байна. Нэгдсэн хөтөлбөртэй 14 аймгийн 8 нь хөтөлбөрийг үнэлэх шалгуур үзүүлэлттэй, үүнээс 3 нь суурь болон зорилтот түвшинг тодорхойлсон бол 2 нь зорилтот түвшинг тодорхойлж, суурь түвшинг тодорхойлоогүй байна. Булган, Дундговь, Орхон, Хөвсгөл аймгууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, төсвийг тодорхой заасан бол бусад яам, агентлаг, аймгууд санхүүгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө, бусад эх үүсвэр гэж заан төсвийг тодорхой тусгаагүй нь хөтөлбөрийн хэрэгжилт хангагдахгүйд хүргэж байна.

Хүснэгт 2. Хөгжлийн бодлогын баримт бичгийн мэдээлэл /байгууллагаар/

Д/д	Байгууллага	Хүний нөөцийн хөгжлийн бодлогын баримт бичиг				
		ШҮ-тэй	Суурь болон зорилтот түвшинг	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг үнэлэх	Санхүүжүүлэх эх үүсвэр тодорхой эсэх

			тодорхойлсон	төлөвлөгөөтэй	журамтай	
1	Яам-4 (БЯ, ГБХНХЯ, СЯ, ЭХЯ)	2	2	1	2	УТ, Зээл тусламж, бусад эх үүсвэр зэргээр тодорхойлсон.
2	Агентлаг (ГИХГ, ОӨГ, АЕГ,)	-	-	-	1	Өөрийн орлого, төрийн болон ОУ-ын байгууллагын дэмжлэгээр гм.
3	Аймаг (БӨ, БУ, ГАА, ДГ, ДО, ДУ, ОР, ӨВ, ӨМ, СҮ, СЭ, ТӨ, ХӨ, ХЭ)	8	5	14	-	БУ 6,2 тэрбум, ДУ 4,7тэрбум, ОР Тухайн байгууллагын төсвийн 0.5%-ийг төлөвлөх, ХӨ Тухайн жилийн байгууллагын төсвийн 0.5%-иас багагүй хувийг сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд зарцуулна. Бусад нь УОНТ, Байгууллагын төсөв, Гадаадын төсөл хөтөлбөр, хандив тусламжийн хөрөнгө

Зарим аймаг, нийслэлийн төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийг аймгийн Засаг даргын захирамж болон байгууллагын даргын даргын тушаалаар баталсан нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйл “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх”-ийн 35.1.8 дахь заалт “нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах,” гэж заасантай нийцэхгүй байна.

Аймаг, нийслэл, төрийн захиргааны төв байгууллагуудын хүний нөөцийн бодлого, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, санхүүжилт, үнэлгээний шалгуур тодорхой бус байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн зорилтот хөтөлбөртэй нийцэхгүй, хэрэгжилтийг тооцох боломжгүйд хүрч байна.

2.2. Төрийн байгууллагуудын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрт мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжсэн арга хэмжээ тусаагүй байна.

Төрийн албанд ажиллаж байгаа мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдаас дотоодын их, дээд сургуулийн докторын хөтөлбөрт Эрчим хүний яамны 1 албан хаагч хамрагдаж байгаа бол гадаад улс орны их дээд сургуулийн докторын хөтөлбөрт Ус цаг уур орчны шинжилгээний газрын 1 албан хаагч Хятад улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байна .


Түүнчлэн дотоодын их, дээд сургуулийн магистрын хөтөлбөрт яамдын 4, агентлагийн 6, нутгийн захиргааны байгууллагын 1 нийт 11 албан хаагч, Олон улсын их, дээд сургуулийн магистрын хөтөлбөрт яамдын 2, агентлагийн 2, нийт 6 албан хаагч

суралцаж төгссөн бол нутгийн захиргааны байгууллагын 3 албан хаагч мэргэшсэн инженерийн зэрэг хамгаалсан байна.

Төрийн албаны мэдээллийн технологийн хүний нөөцийн 41 буюу 7% нь мэргэжлээр нь чадавхжуулах дотоодын богино хугацааны зорилтот сургалтад, 20 буюу 3.4% нь Олон улсын мэргэжлийн богино хугацааны сургалтад хамрагдсан байна.

Төрийн захиргааны төв байгууллагуудын хувьд нутгийн захиргааны байгууллагуудтай харьцуулахад мэдээллийн технологийн албан хаагчид гадны төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагаатай олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар богино хугацааны сургалтад хамрагдах боломж илүү байна.


Дүрслэл 2. МТ-ийн албан хаагчдыг богино болон зорилтот сургалтад хамруулсан байдал



Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байдлыг авч үзвэл яамд тухайн албан тушаалдаа 1-2 жил хүртэл хугацаанд ажилласан 17 албан хаагчийн 14 буюу 82.3%-ийг, агентлаг 53 албан хаагчийн 7 буюу 13.2%-ийг, нутгийн захиргааны байгууллага 105 албан хаагчийн 2 буюу 1.9%-ийг чиглүүлэх богино хугацааны сургалтад, яамд тухайн албан тушаалдаа 3-5 жил ажилласан 9 албан хаагчийн 6 буюу 66.7%-ийг, агентлагууд 21 албан хаагчийн 3 буюу 14.2%-ийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамруулсан бол нутгийн захиргааны байгууллагууд 49 албан хаагчийн нэгийг ч мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамруулаагүй байна.

Яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг төрийн захиргааны эрхэлсэн болон ахлах түшмэлийн албан тушаалд ажиллаж байгаа 26 албан хаагч зохих ангиллын мэргэшүүлэх багц сургалтад бүрэн хамрагдсан байна.

Дүрслэл 3. МТ-ын албан хаагчдын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байдал



Хүснэгт 3. МТ-ийн албан хаагчдын мэдээлэл, ажилласан жилээр

Байгууллагын нэр	1 жил хүртэл	1-2 жил	3-5 жил	5-10 жил	10-15 жил	15-20 жил	20-оос дээш жил	Нийт
Яам	15	17	9	4			1	46
Агентлаг	42	53	21	19	9	3	4	151
НЗБ	117	105	49	55	35	16	4	381
Нийт	174	175	79	78	44	19	9	578

Төрийн албаны мэдээллийн технологийн хүний нөөцийн 428 буюу 74% нь тухайн албан тушаалдаа 5 хүртэл жил ажилласан туршлагатай байна.

Яам, агентлагийн хувьд Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад албан хаагчдыг хамруулах болон ажлын байран дахь богино хугацааны сургалтыг зохион байгуулах талаар нэлээд санаачилгатай ажиллаж байгаа бол нутгийн захиргааны байгууллагад квот тогтоодог, байгууллагын төсөв бага зэргээс шалтгаалан хангалтгүй байна.

Төрийн албаны тухай хуульд заасан төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах нийтлэг баталгааг хангах зорилгоор ХЗДХЯ 2 албан хаагчид 6 сая, Гадаадын иргэн харьяатын газар 2 албан хаагчид 1,6 сая, нутгийн захиргааны байгууллагууд 6 албан хаагчид 10,7 сая, нийт 10 албан хаагчид 18,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Төрийн байгууллагууд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад чиглэсэн нийт 26 төрлийн дэмжлэгийн 20-ийг батлагдсан дүрэм журам, байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. (Хуульд заасан нийгмийн баталгааны чиглэл, түүний хэрэгжилтийг хавсралт 3-аас үзнэ үү.) Тухайлбал:

Албан томилолтын зардалд 132 төрийн албан хаагчид 731 хоног 181,09 сая төгрөгийн, албан ажлын хэрэгцээнд хувийн унаа ашигласан 6 албан хаагчид 240,0 мянган төгрөгийн, нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод ажиллахаар томилогдсон ХХААХҮЯ, ЖДҮГ, Орхон аймгийн ЗДТГ, Дундговь аймгийн ЭМГ-ийн нийт 5 албан хаагчид ачаа тээш, зам хоногийн зардал 23,6 сая төгрөгийн, хөдөлмөрийн чадвараа түр алдсан 9 албан хаагчид хөдөлмөрийн чадвараа алдсан хугацаанд цалингийн зөрүү 5,2 сая төгрөгийг, 2 албан хаагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж 689,3 мянган төгрөгийн, 1 албан хаагчид ээлжийн амралтаараа эхнэрийн төрсөн нутаг явах замын зардал 54 мянган төгрөгийн, Магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд сувилуулахаар явсан 5 албан хаагчид замын зардал 6 сая төгрөгийн, магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан 1 албан хаагчид 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний, хууль тогтоомжид заасан бусад (хоол, унаа) нөхөх төлбөрт 64.8 сая төгрөгийн, нийт 281.7 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэхэд Боловсролын яам 1 албан хаагчид 15 сая төгрөг, Гадаадын иргэн харьяатын газар 2 албан хаагчид 16 сая, аймаг нийслэлд 18 албан хаагчид 298,5 сая, нийт 21 албан хаагчид 329,9 сая төгрөг зарцуулсан байна.

Төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгоход олгох буцалтгүй тусламжийг Татварын ерөнхий газар 1 албан хаагчид олгосон бол хууль тогтоомжид заасан бусад тусламж дэмжлэг (хөдөлмөрийн дотоод журамд заасан албан хаагч хурим хийх, шинэ хүүхэд төрөх, гэр бүлийн гишүүд, өөрийн болон хадам эцэг, эх нас барах, г м)-т яамд 10,5 сая, агентлагууд 46,1 сая, нутгийн захиргааны байгууллагууд 106,4 сая, нийт 163.1 сая төгрөг зарцуулсан байна.

Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай

тэнцэх мөнгөн урамшууллыг яамдад 2 албан хаагчид 4 сая, агентлагт 5 албан хаагчид 12,2 сая, нутгийн захиргааны байгууллагад 1 албан хаагчид 1,1 сая, нийт 17,3 сая төгрөг олгосон байна.


Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт Боловсролын яам, ШШГЕГ-ын 401, 405, 407, 409, 415, 421, 435 дугаар хорих ангиуд, Багахангай дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, Хэнтий аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар жилд 2 удаа, бусад яам, агентлаг, нутгийн захиргааны нийт 144 байгууллага жилд 1 удаа, Увс аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Өмнөговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх алба 2 жилд 1 удаа, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Увс аймгийн Улаангом сумын ЗДТГ 4 жилд 1 удаа хамруулсан байна.

Харин Цаг уур орчны шинжилгээний газар албан хаагчдыг эрт илэрүүлэгт хамрагдахад цалинтай чөлөө олгосон бол Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, 22 агентлаг, нутгийн захиргааны 248 байгууллага, нийт 271 байгууллага албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулаагүй байна.

Албан тушаалын цалин хөлс авах, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах, Хөдөлмөрийн тухай хуульд заасан ээлжийн амралт эдлэх баталгаагаар мэдээллийн технологийн албан хаагчид хууль журамд заасны дагуу хангагдсан байна.

Тухайн байгууллага, түүний харьяалагдах салбараас шалтгаалж зөвхөн тухайн салбарын хэмжээний албан хаагчдын нийгмийн баталгааны асуудалд хамаарах нэгдсэн зохицуулалт (тухайлбал НЗДТГ, ХЗДХЯ-ны орон сууцны хөтөлбөр) хийж өгсөн тохиолдолд түүнийг үндэслэн байгууллага нийгмийн баталгааны хөтөлбөртөө тусгах байдлаар хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байгаа нь аудитын явцад ажиглагдаж байна. Гэхдээ энэ нь эргээд салбар, байгууллага дунд нийгмийн баталгааны асуудлыг ялгавартай авч үзэх үндсийг бүрдүүлж байна.


Дүрслэл 4. МТ-ийн албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардал /2019-2024 он, төгрөгөөр/



Аудитад хамрагдсан 578 албан хаагчийн 1 нь Эрдэнийн Очир одонгоор, 7 нь Алтан гадас одонгоор, 2 нь Цэргийн гавьяаны одонгоор, 5 нь эхийн I, II дугаар одонгоор, 44 нь

Хөдөлмөрийн хүндэт медалиар, 1 нь Энхийн төлөө медалиар, 93 нь Салбарын Тэргүүний ажилтан цол тэмдгээр, 152 нь Салбарын Жуух бичгээр, нийт давхардсан тоогоор 305 албан хаагч шагнагдсан байна.

Дүрслэл 5. МТ-ийн албан хаагчдын шагналын мэдээлэл



Төрийн албаны мэдээллийн технологийн хүний нөөцийн 41 буюу 7% нь мэргэжлээр нь чадавхжуулах дотоодын богино хугацааны зорилтот сургалтад, 20 буюу 3.4% нь Олон улсын мэргэжлийн богино хугацааны сургалтад, төрийн албанд анх томилогдсон буюу төрийн албанд 1-2 жил ажиллаж байгаа нийт 175 албан хаагчийн 23 буюу 13.1%-ийг мэргэшүүлэх богино хугацааны сургалтад, 3-5 жил ажиллаж байгаа 79 албан хаагчийн 9 буюу 12%-ийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамруулсан байгаа нь төрийн албаны богино, дунд хугацааны сургалтын бодлогын “Иргэнд төрийн албаны онцлог, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ, эрх зүйн болон төрийн үйлчилгээний стандарт, шаардлагад нийцэн ажиллах мэдлэг чадвар эзэмшүүлэх” зорилгын хэрэгжилт хангагдахгүйд хүрч байна.

Дүгнэлт

1.Төрийн байгууллагууд Төрийн албаны тухай хуульд зааснаар сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж байгаа боловч мэдээллийн технологийн салбарын хүний нөөцөд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.

2.Төрийн байгууллагууд сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрөө салбарын болон орон нутгийн хэмжээнд нэгдсэн, цогц байдлаар, урт дунд хугацааны бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөөтэй уялдсан, хөтөлбөрт суурилсан байдлаар төлөвлөхгүй байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэхгүй байна.

3.Төрийн байгууллагуудын төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт, үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойгүйгээс хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна. Хөтөлбөрт тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүгийн нөөц боломж хомс, байгууллага өөрийн санаачилгаар хэрэгжүүлэх нөөц дутагдалтай, төсөвт тусгагдаагүй, төрийн байгууллагууд төсөвт тусгаж саналаа илгээдэг боловч дэмжигддэггүй байдал хэрэгжилтэд нөлөөлөх гол хүчин зүйл болж байна гэж үзэхээр байна.

4.Төрийн албаны мэдээллийн технологийн хүний нөөцийг сургаж хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь нэг удаагийн шинжтэй, нэгдсэн, цогц байдлаар төлөвлөж хэрэгжүүлээгүй учир салбарын хүний нөөцийн эрэлт, хэрэгцээг хангахуйц үр дүн үзүүлэхгүй байна.

БҮЛЭГ ГУРАВ. ТӨРИЙН АЛБАНЫ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ АЖИЛЛАХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ДУТАГДАЛ ИХ БАЙГАА НЬ МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТ ХЭРЭГЖИХЭД ЭРСДЭЛ ҮҮСГЭХ НӨХЦӨЛ БҮРДЭХЭЭР БАЙНА.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу “Монгол улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т цахим шилжилтийн үеийн 86 зорилт, арга хэмжээ, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, богино хугацааны бодлогын баримт бичиг болох “Улсын хөгжлийн жилийн 2022, 2023 оны төлөвлөгөө” зэрэгт цахим платформ хөгжүүлэх, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим худалдаа, үйлчилгээг нэвтрүүлэх 98, мэдээллийн систем хөгжүүлэх 18, мэдээллийн сан үүсгэх 25, хиймэл оюун ухаанд тулгуурлан хөгжүүлэх 7, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх 2, нийт 150 нарийн мэргэжил, ур чадвар шаардсан арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлж байна.

3.1.Төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр батлагдсан 728 орон тооны 150 орон тоо сул, эзэнгүй, 142 орон тоонд мэргэжлийн бус албан хаагчид ажиллаж байгаа нь нийт орон тооны 40.1%-ийг эзэлж байна.

Хүний нөөцийн аудитад 14 яам, 32 агентлаг, нутгийн захиргааны 661 төрийн байгууллагыг хамруулсан. Үүнээс 14 яам, 32 агентлаг, нутгийн захиргааны 397, нийт 443 байгууллага мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлэх батлагдсан 728 орон тоотой байна. Үүний 685 нь мэдээллийн технологийн чиг үүргийг дангаар, 43 нь бусад чиг үүрэгтэй хавсран хэрэгжүүлэх орон тоо байна.

Яамдын батлагдсан 63 орон тоонд 46 албан хаагч, агентлагуудын 188 орон тоонд 151 албан хаагч, нутгийн захиргааны байгууллагын 477 орон тоонд 381 албан хаагч, нийт 728 орон тоонд 578 албан хаагч ажиллаж, 150 орон тоо сул, эзгүй байна.

Хүний нөөцийн аудитад хамрагдаагүй төрийн албаны мэдээллийн технологийн салбарын чиг үүргийг хэрэгжүүлдэг Мэдээллийн технологийн 6 төвд нийт 337 ажилтан ажиллаж байна. (СЕХ МТТ-9, НДЕГ-ын МТТ-18, Боловсролын МТТ УТҮГ-40, Санхүүгийн МТТ УТҮГ-89, Үндэсний дата төв УТҮГ-67, И Монгол академи-114)

Яамдын мэдээллийн технологийн 63 орон тооны 17 буюу 26.9% нь, агентлагийн 188 орон тооны 37 буюу 19.6% нь, нутгийн захиргааны байгууллагын 477 орон тооны 96 буюу 20.1% нь сул, эзэнгүй байна.

Хүснэгт 4. МТ-ийн албан хаагчдын орон тооны мэдээлэл, албан тушаалын ангиллаар

Байгууллага	Аудитад хамрагдсан байгууллагын тоо	МТ-ийн хүний нөөцийн батлагдсан орон тоо				Одоо ажиллаж байгаа					Сул орон тоо			
		Нийт	ТЗ	ТТ	ТҮ	Нийт	ТЗ	ТТ	ТҮ	Гэрээт	Нийт	ТЗ	ТТ	ТҮ
Яам	14	63	46	3	14	46	35		11		17	11	3	3
Агентлаг	32	188	54	38	96	151	40	23	88		37	14	15	8
Нутгийн захиргааны байгууллага	397	477	167	63	227	381	136	44	181	20	96	31	19	46
Grand Total	443	728	267	104	337	578	211	67	280	20	150	56	37	57

Мэдээллийн технологийн батлагдсан 728 орон тооны 39 буюу 5.3% нь удирдах, 689 буюу 94.6% нь гүйцэтгэх албан тушаал байна. Мэдээллийн технологийн удирдах албан тушаалын 14 буюу 35.8% нь, гүйцэтгэх албан тушаалын 19.7% нь сул, эзэнгүй байна.

Хүснэгт 5. МТ-ны албан хаагчдын орон тооны мэдээлэл, албан тушаалын төрлөөр

Байгууллага	Аудитад хамрагдсан байгууллагын тоо	МТ-ийн хүний нөөцийн батлагдсан орон тоо			Одоо ажиллаж байгаа АХ-ын тоо			Сул орон тоо		
		Нийт	Удирдах	Гүйцэтгэх	Нийт	Удирдах	Гүйцэтгэх	Нийт	Удирдах	Гүйцэтгэх
Яам	14	63	10	53	46	4	42	17	6	11
Агентлаг	32	188	21	167	151	15	136	37	6	31
Нутгийн захиргааны байгууллага	397	477	8	469	381	6	375	96	2	94
Grand Total	443	728	39	689	578	25	553	150	14	136

Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлж байгаа 578 албан хаагчийн 436 буюу 75% нь мэргэжлийн, 23 буюу 4% нь автозам, барилга зэрэг бусад салбарын инженер, 119 буюу 21% нь нягтлан бодогч, эрх зүйч, сэтгүүлч зэрэг бусад мэргэжлийн нийт 142 буюу 25% нь мэргэжлийн бус албан хаагчид байна.

Хүснэгт 6. МТ-ны албан хаагчдын мэдээлэл, мэргэжлээр

Байгууллага	Яам	Агентлаг	Нутгийн захиргааны байгууллага	НИЙТ
Мэдээллийн систем	6	6	20	32
Мэдээллийн аюулгүй байдал	1	4	1	6
Програм хангамж	12	48	106	166
Мэдээллийн сүлжээ	4	4	18	26
Компьютерын техник хангамж	1	12	15	28
Мэдээллийн технологи	8	21	21	50
Компьютерын инженер	1	5	5	11
Компьютерийн ухаан		1	6	7
Мэдээлэл, номын сангийн автоматжуулалт		1	1	2
Электроник, электрон систем	2	1	8	11
Мултимедиа технологи		1	2	3
Холбооны инженер	1	4	21	26
Компьютерийн график дизайн	2	3	15	20
Мэдээлэл зүйн багш	1	7	19	27
Компьютер хэл шинжлэл			7	7
Математик, статистик	2	5	3	10
Оператор			4	4
Бусад салбарын инженер	3	7	13	23
Бусад мэргэжлийн	2	21	96	119
Нийт	46	151	381	578

Мэргэжлийн бус 142 албан хаагчийн албан тушаалын 99 нь мэдээллийн технологийн чиг үүргийг дангаар хэрэгжүүлэх албан тушаал бол 43 нь бусад чиг үүрэгтэй хавсран хэрэгжүүлэх албан тушаал байна.

Мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлэх 150 орон тоо сул, эзэнгүй, 142 орон тоонд мэргэжлийн бус албан хаагчид ажиллаж байгаа нь нийт 728 орон тооны 40,1%-ийг эзэлж байна. Энэ нь төрийн албаны мэдээллийн технологийн хүний нөөц дутагдалтай байгааг харуулж байна.

Төрийн албаны мэдээллийн технологийн хүний нөөцийн 3 буюу 0.5% нь докторын, 74 буюу 12.8% нь магистрын, 487 буюу 84.2% нь бакалаврын, 5 буюу 0.8% нь дипломын, 6 буюу 1% нь мэргэжлийн болон техникийн, 3 буюу 0.5% нь бүрэн дунд боловсролтой байна.

Докторын боловсролтой 3 албан хаагчийн хувьд автозам, цаг уур, компьютер томографын чиглэлээр боловсролын зэрэг хамгаалсан бол магистрын зэрэгтэй албан хаагчдын 53 буюу 71.6% нь мэдээллийн технологийн чиглэлээр боловсролын зэрэг хамгаалсан, 31 нь ОУ-ын мэргэжлийн чиглэлийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байна.

Хүснэгт 7. МТ-ны албан хаагчдын мэдээлэл, боловсролын зэргээр

Байгууллага	Докторын боловсрол	Магистрын боловсрол	Бакалаврын боловсрол	Дипломын боловсрол	Мэргэжлийн болон техникийн боловсрол	Ерөнхий боловсрол /бүрэн дунд/	Нийт
Яам	1	18	27				46
Агентлаг	1	25	125				151
Нутгийн захиргааны байгууллага	1	31	335	5	6	3	381
НИЙТ	3	74	487	5	6	3	578

Аудитад хамрагдсан 443 төрийн байгууллагын мэдээллийн технологийн хүний нөөц (578 албан хаагч)-ийн 14.5% нь мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжлийн албан хаагчид байгаа нь салбарын хэмжээнд хүний нөөцийг бэлтгэх, сургах, хөгжүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлж байгаа албан хаагчдыг төрсөн оноор авч үзвэл 1979 оноос өмнө төрсөн албан хаагчид 40 буюу 6.9%-ийг, 1980-1990 онд өрсөн албан хаагчид 238 буюу 41.2%-ийг, 1990-2000 онд төрсөн албан хаагчид 258 буюу 44.6%-ийг, харин мэдээлэл харилцаа холбоо, технологийн салбар эрчимтэй хөгжиж эхэлсэн буюу 2000 оноос хойш төрсөн албан хаагчид 42 буюу 7.3%-ийг эзэлж байна.

Хүснэгт 8. МТ-ны албан хаагчдын мэдээлэл, төрсөн оноор

Байгууллага	Нийт	1979-өөс өмнө	1980-1989	1990-2000	2000-аас хойш
Яам	46	6 (13.0%)	23 (50.0%)	17 (37.0%)	
Агентлаг	151	15 (9.9%)	69 (45.7%)	56 (37.1%)	11 (7.3%)
Нутгийн захиргааны байгууллага	381	19 (5.0%)	146 (38.3%)	185 (48.6%)	31 (8.1%)
НИЙТ	578	40 (6.9%)	238 (41.2%)	258 (44.6%)	42 (7.3%)

Төрийн албаны мэдээллийн технологийн хүний нөөцийн бүрдүүлэлтийг 2023-2024 оноор авч үзэл 137 байгууллагын 374 албан тушаалд сонгон шалгаруулалт зарласан байна. Дээрх албан тушаалын сонгон шалгаруулалтуудад 535 иргэн бүртгүүлснээс 235 иргэний анкет баталгаажиж, 148 иргэний анкет баримт бичиг дутуу, албан тушаалын тодорхойлолтод тавигдах тусгай шаардлага хангаагүй шалтгаанаар цуцлагдаж, 67 иргэн анкетаа бөглөсөн боловч илгээгүй, харин 80 иргэний тусгай шалгалтад оролцох хүсэлтийг зөвшөөрсөн ч анкетаа бөглөөгүй байна. Анкет баталгаажсан 235 иргэний 234 нь шалгалтад

оролцож, тусгай шалгалтын үр дүнгээр нийт 241 албан тушаалын сул орон тоог нөхсөн ч 2 иргэн цалин бага шалтгаанаар тухайн албан тушаалаас татгалзсан байна.

2024 оны 09 сарын 26-ны өдрийн байдлаар төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлэх 150 албан тушаалын сул орон тоо байгаагийн 16 нь 2024 онд шинэчилсэн бүтцээр бий болсон бол 134 албан тушаалын сул орон тоо нь хүүхэд асрах чөлөөтэй, албан хаагч өөр байгууллагад шилжин, сэлгэн ажилласан, 6 сараас дээш хугацааны сургалтад хамрагдах, эрүүл мэндийн асуудал болон өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн шалтгаан (цалин бага)-аар үүссэн байна.

Мэдээллийн технологийн чиглэлийн 134 албан тушаалын сул орон тооны 85 буюу 63.4%-ийг өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, 40 буюу 29.8%-ийг албан хаагч өөр байгууллагад шилжин сэлгэн ажилласан (цалин бага), 9 буюу 6.7%-ийг бусад шалтгаан эзэлж байна.

Мэдээллийн технологийн чиглэлийн 150 албан тушаалын сул орон тооны 56 нь төрийн захиргааны, 37 нь төрийн тусгай, 57 нь төрийн үйлчилгээний албан тушаалд хамаарч байна.

Төрийн захиргааны 56 албан тушаалын сул орон тооны 34 албан тушаалын сул орон тоонд 2023-2024 онд 3-5 удаагийн сонгон шалгаруулалт зарласан боловч иргэд бүртгүүлээгүй байна.

3.2. Зарим яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн технологийн хүний нөөцийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд кибер аюулгүй байдал алдагдсанаар хэвийн үйл ажиллагаа нь доголдож Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулж болох мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий байгууллагыг онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж тодорхойлон, Засгийн газрын тогтоолоор жагсаалтыг батлахаар, мөн Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын кибер аюулгүй байдлыг хариуцсан нэгж эсхүл ажилтантай байхаар заасан байдаг.²

Дээрх хууль тогтоомжийн дагуу аудитад хамрагдсан байгууллагуудаас онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагад үндсэн болон дэмжих мэдээллийн систем, суурь мэдээллийн сан хариуцсан УБЕГ, ГЗБГЗЗЕГ, хилийн боомтын хяналт, удирдлагын систем хариуцсан байгууллага болон улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн систем хариуцсан ГЕГ, ХХЕГ, ГИХГ хамаарч байна. Тус байгууллагуудаас Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас бусад нь кибер аюулгүй байдлын тухайлсан нэгж, ажилтангүй байна. Энэ нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Зарим яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлэх гүйцэтгэх албан тушаалын ангилал зэрэглэлийг төрийн захиргаа (ТЗ), төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл (ТҮМ)-ээр тогтоосон нь Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын

² Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад “онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага” гэж кибер аюулгүй байдал алдагдсанаар хэвийн үйл ажиллагаа нь доголдож Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулж болох мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий байгууллагыг; 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтад “онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтыг батлах;”, 19.2.4.кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан нэгж, эсхүл албан тушаалтантай байх;

6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-тай нийцэхгүй байна.

Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдыг албан тушаалын ангиллаар авч үзвэл тэргүүн түшмэл байхгүй, эрхэлсэн түшмэлд 7, ахлах түшмэлд 19, дэс түшмэлд 185, төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдыг албан тушаалын зэрэглэлээр авч үзвэл төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах бусад байгууллагын албан тушаалын зэрэглэлд 209, төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэлд 38, мэдээллийн технологийн өндөр ур чадвартай албан тушаалын зэрэглэлд 33 албан хаагч ажиллаж байна.

Хүснэгт 8. ТЗ-ны албан хаагчдын мэдээлэл, түшмэлийн ангиллаар

Байгууллага	Төрийн захиргаан албан тушаалын ангиллаар				Нийт
	Тэргүүн түшмэл	Эрхэлсэн	Ахлах түшмэл	Дэс түшмэл	
Яам		4	11	20	35
Агентлаг		2	4	34	40
Нутгийн захиргааны байгууллага		1	4	131	136
Нийт	0	7	19	185	211

Хүснэгт 9. ТҮ-ны албан хаагчдын мэдээлэл, албан тушаалын зэрэглэлээр

Байгууллага	Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлээр			Нийт
	ТҮ	ТҮМ	ТҮМТ1	
Яам	1		10	11
Агентлаг	51	15	22	88
Нутгийн захиргааны байгууллага	157	23	1	181
Нийт	209	38	33	280

Хэдийгээр төрийн албан хаагчдын цалин, урамшуулал нэмэгдэж, нийгмийн баталгаа сайжирч байгаа боловч Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2024 оны 2 дугаар улирлын статистик мэдээнээс үзэхэд улсын дундаж цалин 2,4 сая төгрөг байгаа бол мэдээлэл, харилцаа холбооны салбарын аж ахуйн нэгжийн удирдах ажилтны дундаж цалин 6,5 сая төгрөг, дунд түвшний ажилтны цалин 2,6 сая төгрөг байна. Харин төрийн байгууллагын мэдээлэл, харилцаа холбооны салбарын удирдах ажилтны дундаж цалин 2,6 сая төгрөг, дунд түвшний ажилтны дундаж цалин 1,9 сая төгрөг байна. Төр, хувийн хэвшлийн мэдээлэл, харилцаа холбооны салбар дахь цалин хөлсний хэт ялгаатай байдал нь төрд ажиллах нарийн мэргэжилтний хомсдол үүсэх, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг тогтоон барихад эрсдэл үүсэж байна.

Хүснэгт 10. МТ-ийн албан хаагчдын цалин хөлсний мэдээлэл

Хувийн хэвшил <i>/Нэмэгдэл, нэмэгдэл хөлс тооцоогүй/</i>		Төрийн байгууллага <i>/Нэмэгдэл, нэмэгдэл хөлс тооцсон/</i>	
<i>Ажилласан жил</i>	<i>Цалин /төгрөгөөр/</i>	<i>Ажилласан жил</i>	<i>Цалин /төгрөгөөр/</i>
Удирдах албан тушаалтны дундаж цалин	6,549,000	Удирдах албан тушаалтны дундаж цалин	2,690,772
Ахлах буюу 6-15 жил ажиллаж байгаа албан тушаалтан	4,349,000	Ахлах буюу 6-15 жил ажиллаж байгаа албан тушаалтан <i>/Зэрэг дэвийн нэмэгдэл: үндсэн цалингийн 18-22%; Ажилласан жилийн нэмэгдэл үндсэн цалингийн 6-15%/</i>	2,534,700
Дунд түвшний буюу 3-5 жил ажиллаж байгаа албан тушаалтан	2,682,000	Дунд түвшний буюу 3-5 жил ажиллаж байгаа албан тушаалтан <i>/Ажилласан жилийн нэмэгдэл үндсэн цалингийн 6-15%/</i>	1,901,717
Шинэ буюу 1-2 жил ажиллаж байгаа албан тушаалтан	1,725,000	Шинэ буюу 1-2 жил ажиллаж байгаа албан тушаалтан <i>Ажилласан жилийн нэмэгдэл үндсэн цалингийн 1-2%/</i>	1,608,594

Зарим яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагууд төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлэх гүйцэтгэх албан тушаалын ангилал зэрэглэлийг ялгаатай тогтоосон нь төрийн захиргаа (ТЗ), төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл (ТҮМ)-ээр тогтоосон нь Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-тай нийцэхгүй байна.

Аудитад хамрагдсан 443 төрийн байгууллагын мэдээллийн технологийн хүний нөөц (578 албан хаагч)-ийн 14.5% нь мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн албан хаагчид байгаа нь тухайн чиглэлийн хүний нөөцийн залгамж чанар алдагдах эрсдэл үүсэж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “... мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлнэ.” зорилт хэрэгжихгүйд хүрсэн байна.

Мэдээллийн технологийн чиглэлийн албан тушаалын сонгон шалгаруулалтад иргэд орж тэнцсэн ч цалин бага шалтгаанаар татгалзах, томилогдсон ч тухайн албан тушаалд тогтвор суурьшилтай ажиллахгүй чөлөөлөгдөх явдал их гарч байгаа нь мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаалын цалин хөлс бага, ажлын ачаалал их, төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангагдахгүй байгаатай шууд холбоотой байна.

Дүгнэлт

1.Төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлэх батлагдсан 728 орон тооны 150 орон тоо сул, эзэнгүй, 142 орон тоонд мэргэжлийн бус албан хаагчид ажиллаж байгаа нь нийт орон тооны 40,1%-ийг эзэлж, төрийн албанд мэдээллийн технологийн хүний нөөцийн дутагдал үүсэж Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан “Цахим засаглал”-ын зорилт, арга хэмжээ хэрэгжихгүй байх нөхцөл бүрдсэн байна.

2.Кибер аюулгүй байдлын тухай хуульд кибер аюулгүй байдал алдагдсанаар хэвийн үйл ажиллагаа нь доголдож Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засагт хохирол учруулж болох мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ бүхий онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлын нэгж, ажилтантай байхаар заасан байтал зарим байгууллагууд хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.Төрийн байгууллагууд мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлэх гүйцэтгэх албан тушаалын ангилал зэрэглэлийг ялгаатай тогтоосон нь Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-тай нийцэхгүй байна.

4.Аудитад хамрагдсан төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын 14.5% нь мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн албан хаагчид байгаа нь тухайн чиглэлийн хүний нөөцийн залгамж чанар алдагдах эрсдэл үүсэж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “... мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлнэ.” зорилт хэрэгжихгүйд хүрсэн байна.

5.Мэдээллийн технологийн чиглэлийн албан тушаалын сонгон шалгаруулалтад иргэд орж тэнцсэн ч цалин бага шалтгаанаар татгалзах, томилогдсон ч тухайн албан тушаалд тогтвор суурьшилтай ажиллахгүй чөлөөлөгдөх явдал их гарч байгаа нь мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаалын цалин хөлс бага, ажлын ачаалал их, төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангагдахгүй байгаатай шууд холбоотой байна.

БҮЛЭГ ДӨРӨВ. ТӨРИЙН АЛБАНЫ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ ОЛОН УЛСЫН ДУНДЖААС 25.8%-ИАР, УЛСЫН ДУНДЖААС 21.1%-ИАР ДООГУУР БАЙНА.

Олон улсын төрийн байгууллагууд төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлдэг албан хаагчдын мэдлэг, ур чадварын шалгалт нь төрийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн хэвийн, тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, төрийн үйлчилгээнд шилдэг практик, инновац болон Олон улсын стандарт нэвтрүүлэх, үр ашигтай нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, үүлэн тооцоолол болон дижитал шилжилтэд дэмжлэг үзүүлэхэд онцгой ач холбогдолтой гэж үздэг байна.

Олон улсад мэдээллийн технологийн албан хаагчдын сүлжээний тоног төхөөрөмж тохируулах, удирдах, системийн найдвартай ажиллагааг хангах, программ бичих, хөгжүүлэх, тестлэх, кибер аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын арга хэмжээ авах, орчин үеийн үүлэн систем удирдах, тохируулах, дэмжлэг үзүүлэх, өгөгдөлтэй ажиллах, түүнд дүн шинжилгээ хийх, IT үйлчилгээний удирдлагын аргачлал, стратеги төлөвлөлт хийх, IT төслүүдийг үр дүнтэй удирдах, хэрэгжүүлэх, ерөнхий мэдлэг ур чадварыг баталгаажуулах Олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллагын 20 гаруй шалгалтууд байна.

Монгол Улсад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад мэдээллийн технологийн чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын мэргэшлийг баталгаажуулах, ур чадварыг үнэлэх шалгалтыг Олон улсын албан ёсны эрхтэйгээр Монголын программ хөгжүүлэгчдийн холбоо, Монголын мэдээллийн технологийн инженерүүдийн холбоо, Мэдээллийн технологийн үндэсний парк зэрэг байгууллагууд хэрэгжүүлж байна.

4.1.Төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг 37.8 хувьтай байна.

Аудитын багийн ахлагч, гишүүд төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдын мэдлэг, ур чадварын түвшин, цаашдын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийн технологийн инженерийн шалгалтын агуулга, хамрах хүрээ, Монголд нэвтэрсэн байдлыг судалж, Япон улсад төвтэй Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн шалгалтын зөвлөл (ITPES)-ийн мэдээллийн технологийн инженерийн паспорт болон суурь шалгалтыг сонгож Мэдээллийн технологийн үндэсний парктэй гэрээ байгуулж хамтран ажиллалаа.

Мэдээллийн технологийн инженерийн шалгалт /МТИШ/ нь 1969 оноос үүсэлтэй Япон улсын шалгалтын системд суурилдаг бөгөөд 2000 оноос Азийн бүс нутгийн мэдээллийн технологийн инженерийн ур чадварын нэгдсэн стандарттай болох зорилгоор Азийн орнуудад дэлгэрүүлж, одоогийн байдлаар 12 оронд харилцан хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын шалгалт юм.

МТИШ нь МТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, МТ-ийн мэргэжлийн чиглэл бүрд шаардагдах чадварын түвшинг тодорхойлох, МТ-ийн инженерүүдийн ур чадварыг үнэлэх бодит шалгуурыг тогтоох улмаар сайн инженерүүдийн нийгэм дэх байр суурийг дээшлүүлэх зорилготой байна.

МТИШ нь дараах 4 түвшний 12 шалгалтаас бүрдэх ба Монгол улсад одоогоор 1-3 дугаар түвшний шалгалтыг нэвтрүүлсэн байна.

Түвшин	Мэдээллийн систем / Шигтгэсэн систем									
	Нийлүүлэгчийн тал / Хэрэглэгчийн тал								Бие даасан	
IV Түвшин	Мэргэжлийн шалтгалууд	Мэдээллийн технологийн стратегийн шалгалт	Системийн архитектурын шалгалт	Төслийн менежерийн шалгалт	Сүлжээний мэргэжилтний шалгалт	Өгөгдлийн сангийн мэргэжилтний шалгалт	Шигтгэсэн системийн мэргэжилтний шалгалт	Мэдээллийн асуулгүй байдлын мэргэжилтний шалгалт	IT-ийн үйлчилгээний мэргэжилтний шалгалт	Системийн аудиторын шалгалт
III Түвшин	Мэдээллийн технологийн инженерийн ахисан түвшний шалгалт (AP)									
II Түвшин	Мэдээллийн технологийн инженерийн суурь шалгалт (FE)									
I Түвшин	Мэдээллийн технологийн паспорт шалгалт (IP)									

Шалгалтын агуулгын 62%-ийг технологи, 22%-ийг стратеги, 16%-ийг менежментийн мэдлэг, ур чадварыг үнэлэх асуулт эзэлдэг байна.

Аудитын багаас ОУ-ын мэдээллийн технологийн инженерийн шалгалтын 1-р түвшин буюу мэдээллийн технологийн паспорт шалгалтын агуулгаар нутгийн захиргааны албан хаагчдаас, 2-р түвшин буюу мэдээллийн технологийн инженерийн суурь шалгалтын агуулгаар яам, агентлагийн албан хаагчдаас сорил авахаар шийдвэрлэсэн. Сорилын агуулгад дараах ойлголтуудыг багтаасан. Үүнд:

Технологи-Энэ хэсэгт технологийн үндсэн үг хэллэг, ойлголтын талаарх мэдлэг болон логик сэтгэлгээ, энгийн системийг аюулгүй ашиглахтай холбоотой суурь мэдлэг шалгах асуултуудыг багтааж, мэргэжлийн өндөр түвшний мэдлэг шаардах асуултуудыг оруулаагүй болно.

1. Компьютерын систем: Компьютерын болон системийн бүрэлдэхүүн хэсэг, программ хангамж, техник хангамж, тэдгээрийн шинж чанар
2. Хөгжүүлэлтийн технологи: Систем хөгжүүлэлтийн процесс, туршилтын аргууд, гадна программ хангамж хөгжүүлэлтийн процесс, арга техник
3. Суурь онол: Тооллын системийн үндэс, олонлог, магадлал, статистик, мэдээллийн тоон хувиргалт, алгоритм
4. Технологийн элемент: Хэрэглэгчийн интерфэйс, мультимедиа технологиудын шинж чанар, өгөгдлийн сангийн зохиомж, сүлжээний суурь ойлголт, аюулгүй байдлын арга хэмжээ

Менежмент-Энэ хэсэгт системийн хөгжүүлэлт болон төслийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой үндсэн нэр томъёо, ухагдахууны талаарх мэдлэг шалгах асуултуудыг оруулсан бөгөөд мэргэжлийн өндөр түвшний үг хэллэг, ойлголтын тухай асуултуудыг оруулаагүй болно. Мөн хэрэглээний программ хангамж, компьютер болон сүлжээ ашиглан, бизнесийн орчныг бүрдүүлэх талаарх үндсэн мэдлэг шалгах асуултуудыг багтаасан.

5. Үйлчилгээний удирдлага: Мэдээллийн системийг удирдахад шаардлагатай мэдээллийн технологийн үйлчилгээний удирдлагын бүтэц ба үүрэг, системийн орчны ойлголт, системийн аудитын үндэс
6. Төслийн удирдлага: Төслийн удирдлагын процесс, арга техник

Стратеги-Энэ хэсэгт технологийн үндсэн үг хэллэг, ойлголтын талаарх мэдлэг болон логик сэтгэлгээ шалгасан асуултуудыг оруулж, мэргэжлийн өндөр түвшний мэдлэг шаардах асуултуудыг оруулаагүй болно.

7. Бизнесийн стратеги: Энэ бүлэгт мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга техник, маркетингийн техник, бизнесийн удирдлагын систем, технологийн систем зэрэг бизнесийн стратегитай холбоотой нийтлэг системүүд
8. Системийн стратеги: Бизнесийн процессын ойлголт, бизнесийн үйл ажиллагааг сайжруулах арга техник, мэдээллийн системийн хөгжүүлэлт, компьютержуулалтын шаардлагын тодорхойлолт болон түүний боловсруулалт
9. Байгууллага ба хууль эрх зүй: Байгууллагын үйл ажиллагаа, бизнесийн удирдлага, хууль эрх зүйн нийцэл болон байгууллагын дотоод дүрэм журам

Сорилыг дээрх 3 бүлгийн хүрээнд 9 агуулгаар 50 асуулттай 1 цагийн сорилыг боловсруулан 2024 оны 10 дугаар сарын 04-ны өдөр улсын хэмжээнд нэгдсэн байдлаар Төрийн албаны зөвлөлийн тусгай шалгалтын Open exam цахим системээр зохион байгууллаа.

Сорилд 13 яамны 82, 11 агентлагийн 198, нутгийн захиргааны 245 байгууллагын 290, нийт 570 төрийн албан хаагч хамрагдлаа.

Сорилд хамрагдсан төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдын мэдээллийн технологийн стратегийн мэдлэг Олон улсын дундаж түвшинтэй ойролцоо байгаа бол менежментийн болон технологийн мэдлэг харьцангуй доогуур байна.

Хүснэгт 11 . МТ-ийн албан хаагчдын мэдлэгийн түвшин, ОУ-ын болон Монгол Улсын дундажтай харьцуулснаар

Улс	Технологи				Менежмент		Стратеги			Технологи /62%/	Менежмент /16%/	Стратеги /22%/	Нийт /100%/
	1. Суурь онол	2. Компьютерийн систем	3. Технологийн элемент	4. Систем хөгжүүлэх технологи	5. Төслийн удирдлага	6. Үйлчилгээний удирдлага	7. Байгууллага ба эрх зүй	8. Бизнесийн стратеги	9. Системийн стратеги				
Филиппин	41.5	50.9	78.9	77.5	76.2	40.3	58.7	49.8	62.6	38.6	9.3	12.5	60.4
Мьянмар	50.9	84.2	64.3	68.7	52.3	67.4	51.5	42.6	63.1	41.6	9.6	11.5	62.7
Тайланд	53.7	55.1	49.5	79.4	60.8	68.5	70.3	64.6	55.4	36.8	10.3	14.0	61.1
Вьетнам	55.8	52.1	72	80.1	80.4	78.2	66.9	62.3	70.1	40.3	12.7	14.6	67.6
Бангладеш	60.2	65.3	72.1	71.6	60.9	64.5	67.9	60.8	72.7	41.7	10.0	14.8	66.5
ОУ-ын дундаж	52.42	61.52	67.36	75.46	66.12	63.78	63.06	56.02	64.78	39.8	10.4	13.48	63.67
Монгол улсын нийт үр дүн*	62.3	53.6	64.4	69.1	60.2	51.3	45.1	57.9	51.5	38.7	8.9	11.3	58.9
ТАЗ туршилтын сорилын үр дүн	18	26	47	33	35	40	50	46	76	19.2	6.0	12.6	37.8

Шалгалтын нийт үр дүнгээс харахад яам, агентлагийн мэдээллийн технологийн албан хаагчдын тооллын системийн суурь, олонлог, магадлал, статистик, мэдээллийн тоон хувиргалт болон алгоритмын тухай зэрэг суурь онолын мэдлэг дунджаар 7-11%-ийн

үнэлгээтэй байгаа нь инженерийн суурь мэдлэгийг их, дээд сургуульд сурснаас хойш дахин сэргээж, мэдлэгээ бататгаагүй, нөгөө талаар ажлын байранд тэр болгон хэрэглээд байдаггүйтэй холбоотой гэж үзэж байна.

Хүснэгт 12. МТ-ийн албан хаагчдын мэдлэгийн түвшин, шалгалтын агуулгаар

Яамдын нэр	Технологи				Менежмент		Стратеги		
	Суурь онол	Компьютерын систем	Технологийн элемент	Систем хөгжүүлэх технологи	Төслийн удирдлага	Үйлчилгээний удирдлага	Байгууллага ба эрх зүй	Бизнесийн стратеги	Системийн стратеги
Яам	11.3%	29.7%	57.0%	39.5%	48.0%	49.8%	63.3%	56.5%	100.0%
Агентлаг	7.3%	23.5%	50.1%	31.7%	35.3%	47.1%	65.9%	49.3%	100.0%
Нутгийн захиргааны байгууллага	30.3%	25.2%	32.9%	29.8%	22.0%	26.3%	27.3%	36.6%	28.8%
Дундаж үнэлгээ	16.3%	26.2%	46.7%	33.7%	35.1%	41.1%	52.2%	47.4%	76.3%

Мөн яам, агентлагийн мэдээллийн технологийн албан хаагчдын технологийн элемент, менежмент, стратегийн талаарх мэдлэг 49-63%-тай буюу хамгийн өндөр байгаа нь салбарын бодлого тодорхойлох, дүрэм журам боловсруулах, байгууллагын систем, сүлжээ, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажилладаг чиг үүрэгтэй нь холбоотой байна.

Нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн технологийн албан хаагчдын суурь онолын мэдлэг яам, агентлагаас өндөр байгаа нь тухайн байгууллагуудад дөнгөж сургууль төгссөн, төгсөөд удаагүй залуу боловсон хүчнүүд ажилладагтай холбоотой гэж үзэж болохоор байна.

4.2.Төрийн өгөгдлийн сангууд, түүний бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангах, улмаар төрийн байгууллагуудад мэдээллийн шинэ технологийн (их өгөгдлийн технологи, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжлэх ухаан г.м) мэдлэг, ур чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх сорилт тулгарч байна.

Олон улсын хэмжээнд мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлт болон Дэлхийн эдийн засгийн форумаас 2020 онд тус чиглэлээр гаргасан судалгаа, БНХАУ, ХБНГУ, Канад, Сингапур улсуудын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал, чиг хандлагыг харьцуулан судлахад Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дижитал шилжилтийн үйл явц эрчимжиж, үүнийг даган дэвшилтэт технологийг нэвтрүүлж байгаатай холбоотойгоор шинэ ажлын байрууд бий болж, өгөгдлийн шинжээч, хиймэл оюун ухаан болон машин сургалтын мэргэжилтэн, мэдээллийн аюулгүй байдлын шинжээч, их өгөгдлийн болон дижитал шилжилтийн мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж, аналитик сэтгэлгээ, инновацын ур чадвар, идэвхтэй суралцах, сурах стратеги, асуудлыг цогцоор нь шийдвэрлэх ур чадвар, бүтээлч-өвөрмөц байдал, санаачилга, манлайлал, сэтгэл хөдлөл, стресс удирдах ур чадвартай мэргэжилтний эрэлт өндөр байгаа тухай тоон мэдээлэл байна. Тухайлбал, эрэлт нь өсөж байгаа мэргэжлийн чиглэлийг авч үзвэл:

Хүснэгт 13. МТ-ийн эрэлт өсөж байгаа мэргэжлийн чиглэл, улсаар

Д/д	КАНАД	ХЯТАД	ГЕРМАН	СИНГАПУР
1	AI болон машин сургалтын мэргэжилтэн	Өгөгдлийн шинжээчид	Өгөгдлийн шинжээчид	Өгөгдлийн шинжээчид
2	Өгөгдлийн шинжээч	AI болон машин сургалтын мэргэжилтнүүд	AI болон машин сургалтын мэргэжилтнүүд	AI болон машин сургалтын мэргэжилтнүүд
3	Процессын автоматжуулалтын мэргэжилтэн	Их өгөгдлийн мэргэжилтнүүд	Дижитал шилжилтийн мэргэжилтнүүд	Дижитал шилжилтийн мэргэжилтнүүд
4	МАБ-ын шинжээч	МАБ-ын шинжээчид	Их өгөгдлийн мэргэжилтнүүд	Их өгөгдлийн мэргэжилтнүүд
5	Программ болон аппликейшн хөгжүүлэгч	Дижитал шилжилтийн мэргэжилтнүүд	IoT мэргэжилтнүүд	МАБ-ын шинжээчид
6	IoT мэргэжилтэн	Их өгөгдлийн мэргэжилтнүүд	МАБ-ын шинжээчид	Дижитал маркетинг, стратегийн мэргэжилтнүүд
7	Их өгөгдлийн мэргэжилтэн	Дижитал маркетинг, стратегийн мэргэжилтнүүд	Төслийн менежерүүд	IoT мэргэжилтнүүд
8	Математикч, статистикч	Нийлүүлэлтийн сүлжээ, логистикийн мэргэжилтнүүд	Программ болон аппликейшн хөгжүүлэгчид	Финтек инженерүүд
9	Финтек инженер	Финтек инженерүүд	Өгөгдлийн сан ба сүлжээний мэргэжилтнүүд	Хөгжүүлэгч инженер
10	Дижитал шилжилтийн мэргэжилтэн	Угсралт, үйлдвэрийн ажилчид	Процессын автоматжуулалтын мэргэшсэн ажилтнууд	Өгөгдлийн сан ба сүлжээний мэргэжилтнүүд

Манай Улсын хувьд их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч болон төгсөгчдийн тоон мэдээлэлд үндэслэн салбарын хүний нөөцийг тооцбол ирэх 5 жилд мэдээллийн технологийн чиглэлээр 8200 орчим (ИДС төгсөгчдийн тоог 5400, МСҮТ-ийн төгсөгчдийн тоо 2800) ажиллах хүч хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэгдэх (нийт төгсөгчид 100 хувь мэргэжлээрээ ажилд орно) хэдий ч 2029 он хүртэл шинээр бий болох мэдээллийн технологийн чиглэлийн ажлын байрны 31.6 орчим хувь (3801) нь мэргэжлийн хүний нөөцийн дутагдалд орхоор байна.

Хүснэгт 14 . МТ-ийн чиглэлийн ажилтны өсөлтийн таамаглал

Ажиллагчдын төрөл	2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он	2029 он
ICT салбарын ажилтан	9278	9381	9482	9583	9684	9785

Салбарын бус байгууллагад мэдээллийн технологийн ажилтны тоо	37697	40436	42909	45382	47855	50328
Мэдээллийн технологийн чиглэлийн нийт ажилтан	46306	48861	51223	53584	55946	58307
Шинээр үүсэх ажлын байрны тоо	2421	2555	2679	2802	2926	3049

Дүгнэлт

1.Төрийн албаны мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн мэдээллийн технологийн мэдлэг 37.8%-тай, ОУ-ын дунджаас 25.8%-иар, Улсын дунджаас 21.1%-иар доогуур байгаа нь тухайн салбарын хэмжээнд хүний нөөцийн сургалт, хөгжлийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

2.Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлж буй албан хаагчид компьютерын ухааны суурь мэдлэгээ сэргээх, бататгах, мэдээллийн аюулгүй байдал, систем хөгжүүлэлтийн чиглэлээр дэлгэрэнгүй судлах, программ хангамж хөгжүүлэлт дээр ажиллах, турших зэрэгт ажлын байран дээрээ тасралтгүй суралцах шаардлагатай байна.

3.Салбарын хүний нөөцийг сургаж хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгцээ шаардлагад тулгуурласан, олон улсын жишигт нийцсэн, цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

--oOo--

